

МОНГОЛ УЛСЫН ЗХА-ИЙН ГЕОПОЛИТИК

Э.Наран*

Ш.Амжилт**

Монгол Улсын газар зүйн байршлын талаар өрнө дахины газар зүйн мэргэжилтэн, дорно дахины хөрш зэргэлдээ улсууд цөмөөр стратегийн маш чухал ач холбогдолтой гэж үзсээр ирлээ. Орчин үеийн геополитикийн үндэслэгчийн нэг, Английн нэрт газар зүйч, стратегич Mackinader Sir Halfod John (1861—1947) өвөрмөц магадлал хийсэн байна. Тэрбээр 1904 онд Английн “Газар зүйн сар тутмын сэтгүүл”-д нийтэлсэн “Түүхэн дэх газар зүйн хүйс” гэдэг өгүүлэлдээ Азийн дотоод хуурай болон Зүүн Европ (эх хуурайн зүрх) нь “дэлхийн арал”-ын стратегийн төв болсон гэсэн бөгөөд Монголыг “энд бол дэлхийн төв” гэж заасан байна. Mackinader-ын үзсэнээр евразийн эх хуурайн төв хэсгийн тэгш уудам хээр тал нь монголчууд Европыг түрэмгийлэхэд ашигтай байсан байна. Тэр бас хэлэхдээ, хуурай замын зам тээврийн хэрэгслийн хөгжлийн сацуу евразийн эх хуурайн “зүрх болсон хэсэг” хамгийн чухал стратегийн бүс болсон байна.

Дорно дахинд 1927 оны 7-р сард Японы сайд нарын зөвлөлийн дарга Накамүра эзэн хаандаа өргөн барьсан “Эзэнт гүрнээс Манж, Монголд авах идэвхтэй үндсэн төрийн бодлого”-доо: “Хятадыг эрхшээлдээ оруулья гэвэл юуны түрүүнд Манж, Монголыг эрхшээлдээ оруулж авах хэрэгтэй. Дэлхийг эрхшээлдээ оруулж авья гэвэл юуну түрүүнд Хятадыг эрхшээлдээ оруулж авах хэрэгтэй” гэж аюумшиггүй хэлсэн байна. Ингээд “Манж, Монгол”-оор түрэмгийлэх баазаа болгох сагсуу галзуу стратеги тогтоосон байна. Япон 1939 онд Монголыг түрэмгийлэн Халхын голын дайныг дэгдээж, Хятад, Монголыг эзлэн ЗХУ-ыг довтлох оролдлого хийсэн байна. Mackinader эрдэм шинжилгээний талаар, Накамүра практикийн талаар Монголын стратегийн чухал байр суурийг батлан тогтоосон байна. Тэгвэл Монгол нь дэлхийн зүрх мөн эсэхийн талаар нотлогдоогүй байгаа хэдий ч Монгол Улс бол ЗХА болон Төв Азийн бүс нутгийг холбох, цаашилбал евразийн эх хуурайг холбох чухал байр суурьтай мөртөө Хятад, ОХУ хоёр гүрний дунд орших геополитикийн чухал үнэ цэнэтэй билээ. Монголын газар зүйн өвөрмөц байр суурь болон геополитикийн чухал

*Э.Наран - ӨМИС-ийн Хөрш орон судлалын хүрээлэн, доктор, профессор

**Ш.Амжилт - ӨМИС-ийн Хөрш орон судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

чанар нь дэлхийн том гүрнүүд болон хөрш зэргэлдээ улсуудын стратегийн анхаарлыг татсаар ирсэн. Ялангуяа хүйтэн дайны дараа дэлхийн дэглэм дахин тогтож байгаа өнөөдөр Монголын геополитикийн байр суурь улам дээшилсэн байна. Монгол ч өөрийнхөө байгалиас ивээсэн өвөрмөц давуу талаа ашиглан “олон ургальч” тэнцвэртэй гадаад бодлого хөгжүүлэн, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож, улсынхаа нэн их ашгийн төлөө тэмцэж байна.

Нэг. Монгол Улсын “олон тулгуурт” гадаад харилцааны стратеги

1. “Олон тулгуурт” гадаад харилцаа гэж юу вэ?

XX зууны 90-ээд оны эхээр ЗХУ задарч, Зүүн Европод огцом эргэлт гарч, Монголын гадаад орчинд үндсэн хувиралт гарсан байна. Хувиралт гарсан олон улсын байдлын дагуу Монгол орон хагас зууны турш баримталж ирсэн социализмын тогтолцоонд өөрчлөн байгуулалт хийсэн байна. Улс төрийн талаар өрнөдийн олон намт парламентын ардчиллын тогтоолцоо, эдийн засгийн талаар зах зээлийн чөлөөт эдийн засгийн тогтолцоо, гадаад харилцааны талаар урт хугацаагаар хэрэгжүүлсээр ирсэн ЗХУ-ыг л “түшсэн” бодлогоо хаяж, эвсэлд үл нэгдэх, адил зайтай, олон ургальч “олон тулгуурт” гадаад бодлого хэрэгжүүлсэн байна. 1994 оны 1-р сард Монгол Улсын УИХ-ын соёрхон баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-д “олон тулгуурт” гадаад бодлогоо хуульчлан баталсан байна. “Үзэл баримтлал”-д “ОХУ болон БНХАУ-тай найрсаг харилцаатай байх бол Монгол Улсын гадаад бодлогын чухал зорилт”, АНУ, Япон, ХБНГУ болон БНЭУ, БНСУ зэрэг өрнөдийн улсуудтай харилцаагаа хөгжүүлэх болно гэжээ. Монгол Улс өөрийнхөө “олон тулгуурт” гадаад бодлогоо “нэг тогоо тулгын гурван чулуун дээр тогтдог” гэж дүрслэлээр тайлбарласан байна. 2004 оны 9-р сард шинээр бүрэлдсэн Монголын шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт дээрх гадаад бодлогоо дахин дурьдаж чухалчилсан байна. Тухайлбал: 1. Монгол Улсын олон улс дахь байр суурийг бэхжүүлж, “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын чиглэлийг эрс хэрэгжүүлж, бие даасан, нээлттэй, олон тулгуурт идэвхтэй гадаад бодлого явуулна. 2. Гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалан ОХУ болон БНХАУ-ын хоорондох найрсаг сайн хөршийн харилцаагаа бүх талаар бэхжүүлж хөгжүүлнэ. 3. АНУ, Япон, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй улсуудтай хоорондын хамтын ажиллагааны харилцаагаа бэхжүүлж, тэдгээрийн

бодит ашгийг Монгол Улсад татан оруулж, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулна. 4. Ази, Номхон далайн улсуудын хоорондох хамтын ажиллагааны харилцаагаа хөгжүүлэхийн хамт, ЗХА, Төв Азийн олон талт хамтын ажиллагааны процесст идэвхтэй оролцоно. 5. Монгол Улсын аюулгүй байдал болон “цөмийн зэвсэгтгүй байр суурь”-ийг лавтай батлахын тулд НҮБ болон түүний дэргэдэх байгууллага, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон улсын нөлөө бүхий байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны харилцаагаа бэхжүүлэхээр чармайна.

2005 оны 6-р сард тушаалдаа орсон Монгол Улсын дөрөв дэх ерөнхийлөгч Н.Энхбаяр түүний ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх мөрийн хөтөлбөртөө Монголын “олон тулгуурт” гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалах асуудлыг улам нэг алхам чухалчилж, “Монгол Улсын гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалан үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжилд таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн олон тулгуурт, нээлттэй, бие даасан идэвхтэй гадаад бодлого явуулна”¹ гэж тэрээр хэлжээ.

2. “Олон тулгуурт” гадаад харилцаа боловсруулсан үүдэл болон түүний ашиг хор

Монгол Улс “олон тулгуурт” гадаад харилцааны бодлого боловсруулж хэрэгжүүлж байгаа нь төрийнхөө улс төр, эдийн засаг, цэргийн аюулгүй байдлыг үр ашигтай хангахын тулд хийсэн стратегийн сонголт болно. Монгол Улсын “олон тулгуурт” гадаад харилцааны бодлогын ач холбогдол нь:

Нэг. Монгол бол Хятад, Орос хоёр улсын хооронд оршдог дотоод урсгалт жижиг гүрэн, хоёр хөршөө түших чанар ихтэй, Монгол оршин тогтнож, хөгжихөд хоёр том хөршөө салж чадахгүй, тусгаар тогтнол болон хөгжлөө батлахад юуны өмнө хоёр хөрштэйгөө сайн хөршийн найрсаг харилцаагаа хөгжүүлэх хэрэгтэй бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, тэнцвэртэй харилцаатай байх хэрэгтэй. Үүний эсрэгээр энэхүү тэнцвэрт харилцаа эвдэгдэх тохиолдолд Монгол Улс даруй нэг талыг нь хэтэрхий түших бүтэлгүй аргыг дахин хэрэглэж, хөгжил нь хязгаарлагдах нь зайлшгүй болно.

Хоёр. Монгол хэдийгээр Хятад, Орос хоёр том гүрэнтэй сайн хөршийн найрсаг харилцаагаа тэргүүлэн хөгжүүлэх нь чухлаас чухал гэж үздэг хэдий ч, түүхийн шалтгаан болон газар зүйн харьцаанаас болж Хятад, Орос хоёр хөршдөө цөм санаа амар биш байж, адил бус хэмжээний эргэлзээ болон цэрвэлттэй байдаг. Иймээс АНУ, Япон,

ХБНГУ, БНСУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй улсуудтай хоорондох харилцаагаа идэвхтэй хөгжүүлж, цаашилбал АНУ-г “гурав дахь хөрш”-өө гэж байгаа нь Монгол Улс эдгээр улсуудаас улс төрийн дэмжлэг, цэргийн явдал болон эдийн засгийн туслалцаа олохыг сонгосон мөртөө бас том гүрний хүчинд түшиглэн Хятад, Оросыг хязгаарлаж, өөрийн улсынхаа тусгаар тогтнол болон аюулгүй байдлыг хамгаалах зорилгодоо хүрэх болно.

Гурав. Том гүрэнтэй эвсэлд нэгдэхэд оролцохгүй, том гүрэнтэй тэнцүү зайтай харилцаатай байж, аль нэгнийг нь өрөөсгөлөөр дагахгүй, тэнцвэртэй харилцаатай байх нь өөрийнхөө тусгаар тогтнолт чанар болон үйл ажиллагааны хүрээгээ нэмэгдүүлэх мөртөө бас том гүрнүүдийн хоорондох хүчин чадлын тэнцвэрийг ашиглан улс төр, цэргийн явдал болон эдийн засгийн нэн олон ашиг олох болно.

Монголын өнөөгийн баримталж байгаа “олон тулгуурт” гадаад бодлого нь хүйтэн дайны үеийн “нэг тийш хэлбийсэн” бодлоготой харьцуулбал, нэлээд уян хатан чанартай байж, аль ч улсын эрхшээлд орохгүй болох нь илт байна. “Олон тулгуурт” гадаад харилцаа нь одоогоор Монголын улс төрийн хүчнүүдийн нийтийн танилт болж, “олон тулгуурт” гадаад харилцаа Монгол Улсын аюулгүй байдал болон эдийн засгийн ашиг сонирхолд нэн их нийцдэг гэж тэд үзэцгээж байна.

Гэтэл Монгол Улсын гадаад харилцаа ч олон төрлийн хүчин зүйлийн хязгаарлалтыг хүлээж байна. Юуны өмнө улсын хүчин чадал дорой, дотоодын эдийн засаг болон нийгмийн асуудлууд, ядуурал болон ажилгүйдлийн асуудал нэлээд хурцдаж, ялангуяа 36%-ийн хүн амын ядуурал нь Монголын Засгийн газрынхныг ноцтой гачигдуулж байгаа болохоор Монгол Улсын Засгийн газар гол анхаарлаа дотоод хэрэгтээ төвлөрүүлэх хэрэгтэй.

Дараа нь шилжилт хийснээс хойш Монгол Улс гадаадын хөрөнгө их хэмжээгээр татан оруулж, эдийн засгаа хөгжүүлэх бодлого хэрэгжүүлсээр ирсэн хэдий ч Монголын хөрөнгө оруулалтын орчин төгөлдөржиж чадаагүй. Гадаадын худалдаачныг хамгийн их толгой өвтгөдөг нь дэд бүтцийн барилга байгууламжийн нөхцөл дорой, ялангуяа ашигт малтмалын баялаг ихтэй өмнө хэсгийн говийн бүсэд ус, цахилгаан, замын хангалт муу. Хууль зүйн үйлчилгээ ч сул болохоор Монголын хууль гурван хоног хэрэгждэг гэж шоолдог. Мөн Монголын зарим аж ахуйн нэгж болон бизнесмен найдваргүй, гадаадтай тохиролцсон гэрээ хэлэлцээрээ дахин дахин өөрчилж, хөрөнгө оруулагч нартаа нэр хүндгүй болдог. Эдгээр холбогдох арга хэмжээг цаг даруйд нь

шийдвэрлэхгүй бол гадаадын хөрөнгө оруулалтанд нөлөөлөх болно.

Мөн Монгол Улс том гүрний тэнцвэрт хүчний хооронд эргэлдэн тэнцвэрээ эрдэг болохоор хүндрэл маш их байдаг. Энэ бүгд нь Монголын гадаад харилцааны орон зайн тэлэн өргөжихөд зохих хэмжээгээр нөлөөлж байна.

Хоёр. Монгол Улсын ЗХА-ийн аюулгүй байдлын стратеги

Монголын аюулгүй байдлын стратеги бол улс төр, гадаад харилцааны арга барилд түшиглэн үндэсний аюулгүй байдлаа хамгаалдаг. Урд, хойт хөрш болох Хятад болон Орос хоёр том гүрэн бол Монголын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхөд нэгдүгээр байр эзэлдэг гэж Монгол Улс үздэг. Өөрийнхөө тусгаар тогтнол болон аюулгүй байдлыг бэхжүүлэхийн тулд Монгол Улс АНУ-ыг түшиж Хятад, Орос хоёр гүрнийг хязгаарлахыг санаачилж байна. Гэхдээ Монгол Улсыг эргэлзээтэй байлгадаг зүйл бол АНУ-тай “Гурав дахь хөрш”-ийн харилцааг хэтэрхий хөгжүүлбэл Хятад, Орос хоёр том хөрш сонор сэрэмж авахаас болгоомжилно. Үүнээс гадна, Монгол бас санаандгүй хэргээс болж “алсын ус амны цангаа тайлахгүй болох” сэтгэгдэл орно. Иймээс Монгол Улс Ази, Номхон далайн аюулгүйн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Хятад, Орос, Япон, БНСУ, БНАСАУ болон Монголоор гол болгож, Канад, АНУ-г элссэн ЗХА-ийн аюулгүй байдлын дэглэм байгуулахаар санаачилж байна. Монгол Улс бүс нутгийн улс төр, аюулгүй байдлын талын хүчинд түшиглэж, бүс нутгийн олон талт аюулгүй байдлын механизм болон ЗХА-ийн бүс нутгийн бусад орны хоёр болон олон талт харилцаагаар дамжуулан өөрийн улсынхаа аюулгүй байдлыг батлах коэффициентыг нэмэгдүүлж байна. Үүний тулд Монгол Улс ЗХА, Зүүн Азийн аюулгүй байдлын олон талт яриа хэлэлцээ болон зөвшилцөөнд идэвхтэй оролцож, хүрээ нь нэлээд тодорхой бүс нутгийн аюулгүй байдлын дэглэмийг түргэн төлөвшүүлэхийг хүсч байна. 1990 оноос хойш Монгол Улс дотоодын болон ЗХА-ийн олон улсын хуралд оролцох болон зохион байгуулах тухай идэвхтэй санаачилсаар ирсэн. Ялангуяа 1998 оноос Монголын Хөгжлийн судлалыг дэмжих төв, Японы Сасакава сан болон хөрөнгө санхүүгийн бүлэглэлийн мөнгөний дэмжлэгээр ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны олон улсын хурлыг жилд хоёр удаа хуралдуулж байна. Хурлын агуулга нь бүс нутгийн эдийн засгийн өөрчлөн байгуулалт болон эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон бүс нутгийн аюулгүй байдал, дэд бүтэц болон олон улсын

хамтарсан тээвэр, экологийн тэнцвэр болон байгаль хамгаалал, боловсролын хамтын ажиллагаа болон соёлын солилцоо зэрэг өргөн цар хүрээг хамарсан байна.

9-р сарын 11-ний хэргээс хойш Ази тив дэлхийн анхаарлын халуун цэгийн нэг болж, Монгол Улс Азийн нэг улсын хувьд хөрш зэргэлдээх аюулгүй байдлын орчин болон эдийн засгийн хөгжлийн үүднээс Азийн улсууд, ялангуяа ЗХА-ийн улсуудын хооронд гадаад харилцаа хөгжүүлэх ажлыг улам хүндэтгэх болжээ. Одоогоор Монгол Улс нь ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхтэй санаачлагч болон оролцогч гишүүн улс болсон байна.

Гурав. Монгол Улсын ЗХА-ийн эдийн засгийн стратеги

1. Ази тивдээ дахин буцаж ирэв

Монгол Улс 1921 онд “тусгаар тогтнол”-оо тунхагласнаас аваад өнгөрсөн зууны 80-аад он хүртэл улс төр, эдийн засаг, цэргийн явдал, гадаад харилцаа зэрэг талаар ЗХУ болон зүүн Европын улсуудтай нэгдэлтэй байж, ялангуяа 1962 онд “ЭЗХТЗ”-д элссэний дараа эдийн засгийн талаар ЗХУ болон зүүн Европын улсуудтай бүрмөсөн интеграцчилалдсан байна. ЗХУ задарсны дараа ЗХУ болон зүүн Европын дэмжлэг ба хөнгөлөлттэй зээлийг олж чадахгүй болсноос Монголын эдийн засагт ихээхэн хүндрэл тулгарч, Монголын гадаад эдийн засаг худалдаа огцом буурч эхэлсэн байна. Гадаад худалдаагаар л жишээлэхэд 1986 онд Монголын гадаад худалдааны хэмжээ 1.856 тэрбум ам.доллар байсан бол 1990 онд 1.58 тэрбум ам.доллар болж 15% буурсан байна. 1998 он болоход Монголын гадаад худалдаа дөнгөж 789 сая ам.доллар болж 12 жилд 57.5% буурсан байна. Энэ нь худалдааны түших хэмжээ 60% (1989 он) байж, гадаад эдийн засаг худалдаагаар УААА-н амин судас болгож байсан Монголд авч хэлбэл хүнд ноцтой цохилт болох нь сэжиглэшгүй билээ. Мухардлаас гарч эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалъя гэвэл Монгол хамтран ажиллах шинэ түнш хайх хэрэгтэй болсон байна. Иймээс Монгол нь өөрийнхөө олон улсын улс төр эдийн засаг дахь байр сууриа дахин шинжин харахгүй байж болохгүй болж Азидаа дахин буцах, тухайлбал ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн олон улсын хамтын ажиллагаанд оролцох асуудлыг гадаад эдийн засаг худалдааг хөгжүүлэх чухал агуулгаа болгосон байна.

Үүнээс гадна ЗХУ-ын “хамгаалал”-аас салаад удаагүй байсан Монгол орон дахин бусад улсын дагалт болох духгүй болов. Иймээс

1994 онд Монгол Улсын УИХ-ын соёрхон баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-даа, “Эдийн засгийн харилцаа хөгжүүлэхдээ эдийн засаг, нэн ялангуяа стратегийн ач холбогдолтой салбарт нэг буюу хэсэг орны ноёрхол тогтох, Монгол орноо бусад орны харьяат байдалд орох, түүхий эдийн хавсаргаа болохоос сэргийлнэ” гэж заасан байна. Ингээд Монгол Улс ЗХА-ийн хүрээн дэх хос тал болон олон талт хамтын ажиллагааны төсөлд идэвхтэй оролцохыг санаачилсан байна. Тухайлбал “Түмэн голын хөгжлийн төлөвлөгөө”, “Хятад, Оросын байгалийн хийн хоолойн төсөл”-д оролцох хүсэлтэй байж, Канадын Айвэнхо ашигт малтмалын компани, Японы Санжин ашигт малтмалын компанитай Оюутолгойн зэс алтны ордыг хамтран нээх төсөл зэрэг үндэстэн дамнасан хамтарсан төсөл зэргийг байгуулж, харилцан түшиглэж, зохицолдсон тогтвортой тэнцвэртэй олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны механизм байгуулж, өөрийн орныхоо эдийн засгийн ашиг болон аюулгүй байдлыг хамгаалахыг зорьсон байна.

2. Эдийн засгийн харилцан нөхвөрлөл

Шилжилтийн үеэс хойш Монгол Улс төлөвлөгөөт эдийн засгийн хүлээслэлээс мултарч, зах зээлийн эдийн засгийн замд орсон хэдий ч түүний эдийн засаг нь дараалан буурсан байна. Монголын хүн бүрийн дундаж орлого 1989 онд 1000 ам.доллар байснаа 1991 онд 100 ам.доллар² ч хүрэхгүй болж огцом буурсан байна. Сүүлийн жилүүдэд эдийн засаг нь сэргэж, ихээхэн хөгжиж, 2004 онд Монголын эдийн засгийн өсөлт 10.6%-д хүрч, ДНБ 1.2 тэрбум ам.долларыг давсан байна. Гэвч 1989 оны 2.82 ам.долларын улс ардын орлогын төвшнөөс мөн ихээхэн зөрөөтэй байна. Эдүгээ Монголын эдийн засаг мөн мухардлаасаа гарч чадаагүй, суурь нь дорой, эдийн засгаа хөгжүүлэх хөрөнгө мөнгө болон техник хомсдолтой, ажилгүйдэл болон ядуурлын асуудал ноцтой байсаар байна. Тэгэхэд ЗХА-ийн бүс нутагт дэлхийн эдийн засгийн хүчирхэг улс болон түргэн хурдаар хөгжиж байгаа шинэхэн аж үйлдвэрийн улс болон хөгжиж байгаа улсууд төвлөрч, олон улсуудын хоорондох эдийн засгийн харилцан нөхвөрлөх чанар маш их байна. ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хөгжил маш тэнцвэргүй, гэтэл энэхүү тогтворгүй байдал нь сайн талыг нь авч саар талаа нөхөх, давуу талаа харилцан нөхвөрлөхөд маш ашигтай байдаг. Иймээс Монгол Улс ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох нь хөрөнгө мөнгө, техник оруулж ирж чадах мөртөө дэвшилтэт удирдлагын

загвар оруулж ирж болох юм. Эдгээрийн өөрийн орныхоо баялаг ашигт малтмал, мал аж ахуйн түүхий эд, аялал жуулчлалын баялаг болон евразид нэвтрэх зам тээврийн зангилааны давуу талтай уялдуулбал Монголын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх нь зайлшгүй. Одоогоор Монгол болон ЗХА-ийн улсуудын эдийн засгийн хамтын ажиллагаа түргэн хөгжиж байна.

1. Монгол, Орос: Хэдэн арван жилийн турш Монгол, Оросын эдийн засгийн хамтын ажиллагаа ихээхэн буурч, 1986 онд 1.55 тэрбум ам.доллар байснаа 1998 онд 180 сая ам.доллар болж хамгийн бага цэгтээ хүрсэн хэдий ч, сүүлийн жилүүдэд Монгол, Оросын худалдааны хэмжээ сэргэж эхэлсэн бөгөөд Орос нь Монголын импортын зах зээлд мөн л дэлхийн улсуудын дотор тэргүүлсээр байна. 2004 онд Монгол, Оросын худалдааны хэмжээ 487 сая ам.доллар болон өссөний дотор Монгол Улс Оросоос 336.5 сая ам.долларын бараа импортлосон нь Монголын нийт импортын хэмжээний 33.3%-ийг буюу нэгдүгээр байр эзэлж байна. Монголын 90-ээс дээш хувийн газрын тос ба баруун гурван аймгийн эрчим хүч (жилд 450—500 саяквт/цаг) бүгдийг Оросоос импортлоход түшиглэдэг. 2004 онд Монгол 190 сая ам.долларын бензин болон дизелийн түлш импортлосны дотор Оросоос импортлосон нь 172.3 сая ам.долларт хүрсэн нь нийт бензин болон дизелийн түлшний импортын хэмжээний 91%-ийг эзэлж, үлдсэн хэсгийг Хятад болон Казахстангаас импортолсон байна.

Монголд хөрөнгө оруулж байгаа талаар, ОХУ тусгаар тогтносоос 2004 оны эцэс гэхэд Оросын 425 аж ахуйн нэгж Монголд 36 сая ам.долларын³ хөрөнгө оруулж, уул уурхай, барилгын материал, банк санхүү, хүнсний бүтээгдэхүүн болон худалдаа үйлчилгээний салбарт хөрөнгө оруулсан байна. Оросын Монгол дахь хөрөнгө оруулалт худалдаа нь ЗХУ-ын үеийн монополь байр сууриа алдсан боловч ЗХУ-ын үед туслалцаа үзүүлж байгуулсан гурван том хамтарсан аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн нь мөн л Монголын GDP-ын 40%-ийг эзэлж, түүний бүтээгдэхүүний экспортлолт нь Монголын нийт экспортын 60%-ийг эзэлж байна. ОХУ нь Монгол Улсын эдийн засагт голлох аж үйлдвэр, тухайлбал эрчим хүч нийлүүлэх, төмөр зам, уул уурхайд чухал нөлөө үзүүлж, нэлээд их хэмжээгээр захирч байгааг үүнээс мэдэж болно. Иймээс ОХУ-ын Монгол дахь нөлөөг бусад хэн ч орлуулж чадахгүй.

2. Монгол, Хятад: 1998, 1999 онд Хятад орон Монголд хамгийн том хөрөнгө оруулагч ба худалдааны хамгийн том түнш болсноос Хятадын Монгол дахь эдийн засгийн нөлөө өдөр ирэхүйеэ өргөжиж

байна. Монголын эдийн засгийн сэргэжийг дагалдан 2004 онд Монголын гадаад худалдааны нийт хэмжээ 1.865 тэрбум ам.долларт хүрч, урьд оньхоос 31.6% өсч, түүхэндээ хамгийн их хэмжээнд хүрсэн байна. Үүнд Хятад, Монголын худалдаа 690 сая ам.доллар, экспорт 230 сая ам.доллар, импорт 460 сая ам.долларт хүрч, тус бүр 57.7%, 49.7% ба 62.1% өсөн, худалдааны хамгийн том түнш, хамгийн том экспортлогч улс ба хоёрдугаар том импортын эх үүсвэрийн улс болох байр сууриа үргэлжлэн баталсан байна. 2004 онд Хятадын экспортын барааны нийт хэмжээ Монгол Улсын экспортын нийт хэмжээний 47.8%-ийг эзэлж, зэсийн баяжмалаар авч үзэхэд л Хятад руу 280 сая ам.долларын зэсийн баяжмал экспортлосон нь Хятадын импортлосон зэсийн 25%-ийг эзэлж байна. Одоо Монголын 60%-ийн бараа Хятадад экспортолж, 18%-ийн импортын бараа нь Хятадынх бөгөөд Хятадын зэс, алт болон нүүрс зэрэг баялгийг улам нэг алхам олборлох болон Хятадын эдийн засгийн хөгжил нь баялгийн эрэлт ихсэж байгаа болохоор Хятад, Монголын худалдаа мөн өргөжих болно. 2004 оны сүүлч гэхэд Хятадын 1601 аж ахуйн нэгж Монголд 523.38 сая ам.долларын хөрөнгө оруулсан нь Монгол дахь гадаадын хөрөнгийн 40.7%-ийг эзэлж байна. Үүнд 2003 онд Хятадаас Монголд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн төсөл 342 болж, хөрөнгө оруулалтын хэмжээ 46.3 сая ам.долларт хүрэв. 2004 онд 471 аж ахуйн нэгж болон нэмэгдэж, хөрөнгө оруулалтын хэмжээ нь 125.9 сая ам.доллар болж, Монголын гадаадын хөрөнгийг ашигласан төслийн нийт тоо болон хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 53.9% ба 53.2%-ийг тус эзэлсэн байна. 2004 оны эцэст Хятадаас Монголд оруулсан хөрөнгийн 68.6%, тухайлбал 259 сая ам.доллар нь уул уурхайн салбарт төвлөрч байгаа бөгөөд нэг л жилд хоол хүнс болон худалдааны салбарыг давсан байна. Энэ бол хоёр тал 2003 онд Ху Жиньтао даргын Монголд айлчлах үеэр хоёр талын тохиролцсон голдуу баялгийн хүрээнд хамтран ажиллах хэлэлцээрийг идэвхтэй баталгаажуулсны үр дүн болно.

3. Монгол, Япон: 1990 онд Япон Монгол худалдааны хэлэлцээр байгуулснаас хойш хоёр орны худалдаа, эдийн засаг тасралтгүй хөгжиж, Япон нь Монгол руу хэлбийх байдал гарсан байна. Сүүлийн жилүүдэд хоёр талын худалдаа, эдийн засаг хэлбэлзлийн дунд алгуур өсч байна. Монголын статистикийн материалаас харахад Монгол, Японы хоёр талын худалдаа 1990 онд 17.4 сая ам.доллар байснаа 1999 онд хамгийн их хэмжээнд хүрч 125.9 сая ам.доллар болж 7 дахин өссөн байна. Дараа нь 2002 онд буураад 49.1 сая ам.доллар болсноо 2004 онд өсөөд 107.9

сая ам.доллар болсон байна. 2004 онд Монгол Улс Японоос 74.5 сая ам.долларын бараа импортолж, Японд 33.5 сая ам.долларын бараа экспорложээ. Хоёр талын худалдаанд Монгол Улс ерөөс тохиролгүй тэнцэлт байдалд байна. Одоогоор Монгол, Японы худалдааны хэмжээ нь Хятад, ОХУ, АНУ, Английн дараагаар 5-р байр эзэлж байна. Ялангуяа дурдуштай нь Япон бол Монголд эдийн засгийн туслалцаа үзүүлдэг нэгдүгээр том гүрэн юм. 1991-2004 он хүртэл Японоос Монголд 128.28 тэрбум иен (1.2 тэрбум ам.доллар) эдийн засгийн туслалцаа үзүүлсэн нь Монголын нийт гадаад зээл болон нийт тусламжийн 70%-ийг эзэлсэн байна. Япон улс жил бүр Монголд 45-50 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 30-35 сая ам.долларын буцалтгүй тусламж, 10 сая гаруй ам.долларын шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагааны туслалцаа үзүүлдэг. Монгол Улсын хүн бүрийн Японоос олсон дундаж тусламж дэлхийд тэргүүлж байна. 1991-2003 онд Японы Засгийн газраас даргалж хуралдуулсан Монголд дэмжлэг үзүүлэх хурал 10 удаа хуралдаж, Монголд 3.6 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламж олгохоор амласны 82% нь биелсэн байна. Үүнээс Японы амласан тусламжийн хэмжээ болон биелэлт нь хамгийн их, тусламжийн нийт хэмжээний 40-өөс дээш хувийг эзэлж байна. Энэ бүхэн нь Монголын эдийн засгийн хөгжилд бат бэх суурь тавьж өгсөн байна.

4) Монгол, БНСУ: БНСУ нь Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны чухал түнш болсон байна. Монгол болон БНСУ дипломат харилцаа байгуулах эхний үед тухайлбал 1990 онд хоёр улсын худалдааны хэмжээ 900 мянган ам.доллар байснаа 1998 онд 70.9 сая болж нэмэгдэв. Үүний дараа Азийн банк санхүүгийн хямралаас болж хоёр талын худалдааны хэмжээ огцом буурсан боловч 2000 оноос дахин нэмэгдэж 2002 онд 108.8 сая ам.доллар болж огцом өсч, түүхийн шинэ амжилтад хүрсэн байна. 2002, 2003 онд БНСУ нь Монголын дөрөв дэх том худалдааны түнш байлаа. 2004 онд хоёр талын худалдааны хэмжээ 70.23 сая ам.долларт хүрч, Хятад, ОХУ, АНУ, Англи, Японы дараа зургаадугаар байр эзэлсэн байна. 2004 оны эхээр БНСУ-аас Монголд оруулсан нийт хөрөнгө 80.856 сая ам.доллар байж, Монголд хөрөнгө оруулж байгаа улсын дотор дөрөвдүгээр байр эзэлсэн байна.

2004 оны 2-р сард БНСУ болон Монгол хоёр улс Монголд худалдааны чөлөөт бүс байгуулах хэлэлцээр байгуулсан байна. Үүний тулд БНСУ-аас хөрөнгө гаргаж Монголын Дорнод аймаг, Сүхбаатар аймагт худалдааны чөлөөт бүс байгуулахаар амласан байна. БНСУ, Монголд чөлөөт худалдааны бүс байгуулах тохиол нэгэнт боллоо гэж

Монголын албаныхан болон эрдэм шинжилгээнийхэн үзэгцээж байна. Монгол Улс хойт хэсгийн Алтанбулаг, урд хэсгийн Замын-Үүдэд чөлөөт худалдааны бүс байгуулах мөртөө зүүн хэсэгтээ ч чөлөөт худалдааны бүс байгуулж, гадаадын хөрөнгийг Монголд өрсөлдүүлэх байдал бий болгох гэж байна. БНСУ, Монголд чөлөөт худалдааны бүс байгуулах хамгийн тохиромжтой газар нь Монголын зүүн хэсэг, шинэ технологийн чиглэлээр байгуулах энэ чөлөөт бүс байж болох хамгийн тохиромжтой бүс нутаг бол Дорнод аймаг юм. Дорнодын бүс нутаг дэд бүтэц сайн хөгжсөн, бүс нутгийн хамтын ажиллагааны түшиц газрын нэг юм. БНСУ-ын хөрөнгө оруулагчид хоёр хөршөөсөө тааламжтай хөрөнгө оруулалтын орчин хангаж, БНСУ-тай юуны түрүүнд дэвшилтэт шинэ шинжлэх ухаан технологийн электрон бүтээгдэхүүн хөгжүүлэхийг Монголын тал зорьж байна. Тэнд шинэ технологийн аж үйлдвэрийн парк байгуулахад хүрвэл Монголын Сликаны хөндий тэнд сүндэрлэнэ гэдэгт эргэлзэх зүйлгүй гэж Монголын тал илэрхийлэв.

ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаанд Монгол Улс хоёр талын хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхээс гадна, олон талт хамтын ажиллагаанд нэн сонирхолтой байна. Монгол Улс Түмэн голын бүс нутгийг нээх ажилд оролцох тулгам хүсэлтэй байна. Түмэн голын замаар дамжин далайд гарах хамгийн богино зайтай гарцаар Японы далайд нэвтрэхийг хүсэж байна. Ингэвэл Монгол болон Европ, Японы далайг нэг томоохон гүүрээр холбож, энэхүү олон улсын тээврийн шугамаар дамжин Европ болон ЗХА-ийн бүс нутагт чөлөөтэй нэвтэрч, Монголын гадаад харилцааг улам дөхөм дөт, улам өргөжүүлэхийг зорьж байна. Цаашлаад Монголын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдлыг улам сайн хангах болно. Энэ бол Монгол Улсын ЗХА-ийн геополитикийн зорилго болно.

Ашигласан материал

1. Монгол Улсын ерөнхийлөгчид МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярын мөрийн хөтөлбөр, www.songuuli.mn, 2005-04-28.
2. Сумио Курибаяши: "蒙古经济发展战略问题", 《世界经济译丛》1993年第6期
3. Д.Начин. "ОХУ-ын хөрөнгө оруулагчдаас Монголд хөрөнгө оруулсан байдал", "Олон улс судлал", 2005, №1